

НИЙГЭМШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ДАХЬ ХҮНИЙ ЭРХ

HUMAN RIGHTS IN SOCIAL REINTEGRATION ACTIVITIES



Б.Уянга

*ДХИС-ийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял
эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, дэслэгч*

Товч утга: Хорих ял нь дэлхий дахинд хамгийн түгээмэл, хүнд хэлбэрийн эрүүгийн ялд тооцогддог бөгөөд хоригдлын тоо нэмэгдэхийн хэрээр тэднийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх үйл ажиллагааг илүү үр дүнтэй, хүний эрхэд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Энэхүү илтгэл нь хорих ялын зорилго, хоригдлыг нийгэмшүүлэх үйл явцын онол, эрх зүйн үндэслэл, олон улсын чиг хандлага, сайн туршлагыг тоймлон судалсан болно.

Хорих ялын үндсэн зорилго нь зөвхөн гэмт этгээдийг шийтгэх бус, түүнийг засаж хүмүүжүүлэх, нийгэмд дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, эргэн нэгтгэхэд оршино. Хоригдлыг нийгэмшүүлэх нь хувь хүний сөрөг хандлагыг өөрчлөхөөс гадна эерэг дадал, боловсрол, мэргэжлийн ур чадвар олгох цогц үйл ажиллагаа юм. Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон НҮБ-ын холбогдох баримт бичгүүдэд тусгагдсан хүний эрхэд тулгуурладаг.

Илтгэлд хүний эрхэд суурилсан нийгэмшүүлэх үйл ажиллагааны хүрээнд сургалт, нийгмийн халамж, сэтгэл зүйн зөвлөгөө, гэр бүлтэйгээ харилцах орчныг дэмжих зэрэг үндсэн чиглэлүүдийг онцолсон. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй, эмэгтэй, өндөр настай, хүүхэд зэрэг эмзэг бүлгийн хоригдлуудын онцлогт нийцсэн хөтөлбөр, дэмжлэгийн ач холбогдлыг тэмдэглэсэн.

Олон улсын чиг хандлага нь хорих ангиудын зорилгыг зөвхөн ял шийтгэл биш, хүний эрхийг дээдэлсэн, нийгэмд эргэн нэгтгэх үйл явц гэж үзэх болсон бөгөөд Монгол Улсын хорих тогтолцоо ч энэ зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Түлхүүр үгс: Хорих ял, ялын оногдуулалт, олон улсын байгууллага, хоригдлын эрх, нийгэмшүүлэх ажил.

Abstract: Imprisonment is considered the most common and severe form of criminal punishment worldwide. As the number of prisoners increases, there is a justified need to implement rehabilitation and reintegration activities more effectively and in accordance with human rights. This presentation reviews the purpose of imprisonment, the theory and legal basis of prisoner rehabilitation, international trends, and best practices.

The primary goal of imprisonment is not only to punish offenders but also to rehabilitate them, prevent recidivism, and facilitate their reintegration into society. Rehabilitation involves changing negative behaviors of individuals as well as providing comprehensive activities such as positive habits development, education, and professional skills training. This approach is based on human rights as outlined in the Universal Declaration of Human Rights, the International Covenant on Civil and Political Rights, and relevant UN documents.

The presentation highlights key areas within human rights-based rehabilitation activities, including education, social welfare, psychological counseling, and support for maintaining family relationships. It also emphasizes the importance of programs and support tailored to vulnerable groups such as people with disabilities, women, the elderly, and children.

In conclusion, international trends view the objectives of correctional institutions not only as punitive but also as processes respecting human rights and facilitating reintegration into society. The Mongolian correctional system is recognized as needing to implement these principles accordingly.

Key words: Imprisonment, Sentencing, International organization, Rights of detainees, Social reintegration work.

ҮНДСЭН ХЭСЭГ

Дэлхийн II дайнаас хойш хорих ял оногдуулах явдал эрс нэмэгдэж байгааг олон улсын байгууллагууд анхааруулж, энэхүү өсөлтийг бууруулах шаардлагатайг удаа дараа уриалсан боловч зарим бүс нутагт хорих ял оноох хандлага улам бүр хурдацтай өссөн нь хоригдлын эрхэд суурилсан нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх нэг шалтгаан болсон байна.

Энэ нь хоригдлын онцлогийг харгалзан, тэднийг нийгмийн идэвхтэй, үр ашигтай харилцаанд оролцуулах, хүн бүрт тохирсон үе шаттай, зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулснаар нийгэмшүүлэх үйл явц үр дүнтэй

болохыг харуулж байна. Ингэснээр хоригдлыг ёс зүй, эрх зүй, гоо зүй болон бусад үнэт зүйл, үзэл бодлыг ойлгодог, сэтгэхүйн эерэг онцлог бүхий бие хүн болгон төлөвшүүлэх нь нийгмийн зайлшгүй шаардлага хэмээн дүгнэх боломжтой.

Хорих ялын хэрэгжилтэд хийсэн судалгаагаар уг арга хэмжээ нь ихээхэн зардал шаарддагийн зэрэгцээ суллагдсан хүмүүс нийгэмд дасан зохицох чадвар сул, гэмт хэргийг дахин үйлдэх хандлагатай байгаа нь хорих ялыг үр дүн багатай шийтгэлийн төрөлд тооцох шалтгаан болдог. (ДХБХ, 2023) Үүний эсрэгээр, олон улсад "алтернатив ял" гэж нэрлэгддэг хорихоос өөр төрлийн ял нь гэмт хэрэгтнийг шүүхийн шийдвэрийн дагуу нийгмээс бүрэн тусгаарлалгүйгээр тодорхой эрхийг хязгаарлах хэлбэрээр хэрэгждэг.

“Гэвч хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагаа үр дүнтэй, оновчтой зохион байгуулагдаагүй тохиолдолд тэдний гэмт үйлдэл үргэлжилж, нийгэмд сөрөг хандлага, тогтворгүй дадал зуршил улам бүр тархах эрсдэлтэй”. (Батжав Л. , 2003, хууд. 284) НҮБ-аас хорих ял эдлүүлэх нөхцөл, журмын талаар гишүүн орнууд дагаж мөрдөх ёстой нийтлэг стандартыг тогтоосон байдаг. Эдгээрийг үндэсний хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх нь НҮБ-ын гишүүн орны үүрэг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 10.2-т заасан Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой юм.

“Хүний эрхийн түгээмэл тунхаглалын удиртгал хэсэгт”³...хүн үг хэлэх, итгэл үнэмшилтэй байх, эрх чөлөөтэй, айдас, гачигдалгүй ертөнцийг бий болгох нь хүн төрөлхтний эрхэм зорилго мөн” хэмээн тодорхойлсон байдаг. Мөн хүн бүр нэр төр, үнэ цэнтэй орших эрхтэй, эрэгтэй эмэгтэй хүмүүс эрх тэгш байх ёстой, боловсрол эзэмших, хүнсний хангамж, эрүүл мэндийн үйлчилгээ авах, соёл, шинжлэх ухаан, урлагийн бүтээл туурвих, хамгаалуулах эрхтэйг тусгажээ.

Энэ үзэл баримтлалын гол агуулга нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг шийтгэхдээ түүний нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэж, ял эдэлж байх хугацаанд нь хүмүүжүүлэх, боловсрол олгох замаар иргэншсэн, хуулиа дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэх ёстой гэдгийг онцолж буй хэрэг. Энэ

³ “НҮБ-ын Ерөнхий ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан”

нь зөвхөн хууль зүйн асуудал бус, хүний эрхийн үүднээс нийгмийн тогтвортой хөгжилтэй салшгүй холбоотой юм.

Мөн тунхаглалд хүн бүр нийгмийн өмнө үүрэг хүлээдэг бөгөөд зөвхөн нийгмийн орчин л хүний эрх чөлөөт, бүрэн хөгжлийг хангаж чадна гэж заасан. Боловсролын тухайд, энэ нь зөвхөн мэдлэг дамжуулах бус, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх үзэлтэй болгоход чиглэх ёстойг онцолсон байдаг. Иймээс боловсрол нь хувь хүнийг нийгэмд дасан зохицож, зөв төлөвшүүлэх чухал хүчин зүйл гэж үздэг.

Хувь хүний боловсролын ялгаатай байдал, хорих нөхцөл, хоригдлын суралцах хэрэгцээ, сонирхлыг харгалзан хорих байгууллагад тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлага гарч ирдэг. “Тогтвортой хөгжлийн боловсролын тухай” 2014 оны Айчи–Нагоягийн тунхаглалд ч боловсрол нь хүний эрхийн агуулгыг хөхиүлэн дэмжих, нийгмийн дэвшилд чиглэх ёстой гэж тодорхойлсон байдаг. Боловсрол нь шинэ мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхийн зэрэгцээ хувь хүний хандлага, үнэт зүйл, зан төлөвийг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй. (Баярбаатар, 2024, хууд. 74) Тиймээс хорих ял эдэлж буй хүнийг эрх зүй, ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөх, өөрийгөө хүндэтгэх, нийгэмд өөрийн орон зайг ойлгодог иргэн болгон төлөвшүүлэх үйл явц нь хорих байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

“Эрүүгийн бодлого буюу төрийн зүгээс гэмт явдлыг бууруулах зорилтыг хангах оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар нийгмийг гэмт халдлагаас хамгаалах чиглэлээр явуулж буй идэвхтэй үйл ажиллагааны салшгүй хэсэг нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа төдийгүй хорих байгууллага нь төрийн зүгээс нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт явдалтай хийх тэмцлийн чиглэлээр явуулж буй субъект гэж үздэг”. (Очгэрэл, 2017, хууд. 58)

“Тэгвэл хорих байгууллага нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч болохын хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцдаа гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж байгаа хүнд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, нийгэмшүүлэх, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, сургалтад хамруулах, дадлага олгох үүргийг хүлээдэг”. (ХЯЭА, 2025) “Үүнээс үзвэл, нэг талаас хорих байгууллага нь төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч субъект, нөгөө талаас эрүүгийн хуульд заасан эрүүгийн ялын зорилгын хүрээнд гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүний

эрхийг хангах, нийгэмшүүлэх үүргийг хүлээдэг “нийгэмшүүлэх” гэж тодорхойлж болохуйц өвөрмөц чиг үүрэг бүхий байгууллага болох нь харагдаж байна. Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын нэг үндсэн схем нь хүний эрхэд суурилсан мэдрэмжтэй чадвар олгох явдал гэж дүгнэж болно”. (зүйл, 2017)

“НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хурлаар батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын⁴ 10 дугаар зүйлийн 10.3-т зааснаар Ял шийтгэх тогтолцоо нь хоригдлыг засаж залруулах, нийгэмд эргэн нэгтгэх буюу нийгэмшүүлэх үндсэн зорилго байх ёстой гэж заасан нь энэхүү үзэл санааны нэг илрэл юм. Энэхүү пактын агуулга нь хоригдлыг хүнлэгээр харьцах, төрөхөөс заяагдсан хүний эрх, нэр төрийг хүндэтгэх, хорих байгууллага нь шийтгэл оногдуулахын оронд илүүтэй нийгэмшүүлэх буюу засаж залруулахад чиглэх тухай олон улсын зөвшилцлийг илэрхийлсэн бөгөөд үндэсний хууль тогтоомжид нийцсэн, хууль ёсны, хүчин төгөлдөр олон талт гэрээ юм. Үүнтэй адил хорих ял зөвтгөхийн тулд гэмт хэрэгтнүүдийг нийгэмд эргэн нэгтгэх, нийгэмшүүлэхэд бэлтгэх ач холбогдлыг онцолж байна. Тухайлбал, хорих ангид хорих болон хүний эрх чөлөөг хасах ялын зорилго нь нэгдүгээрт нийгмийг гэмт хэргээс хамгаалах, давтан гэмт хэрэг үйлдэх явдлыг бууруулах, мөн нийгэмшүүлэхэд орших учиртайг заасан байдаг. Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны өөр нэг өнцөг нь хоригдлын сөрөг буюу гэмт зан үйлийг засаж залруулахаас гадна эерэг зан төлөвт суурилсан хөгжлийг дэмжихэд чиглэдэг.

Энэ үйл ажиллагааны олон улсын эрх зүйн зохицуулалт нь 1986 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 41/128 тоот тогтоолоор “Хөгжих эрхийн тухай тунхаг” батлагдсанаар өргөнөөр хэрэгжиж эхэлсэн. Хүний хөгжлийн гол үзэл санаа нь хувь хүн чадвар, бололцоотой байх замаар эрхээ эдэлж, хөгжихөд оршино. Хөгжих эрх нь зөвхөн хувь хүний бус, бүлгийн болон нийтийн эрхээ эдлэх үндэс суурь болж өгдөг”. (ХЭҮК, 2016, хууд. 10)

“Хөгжих эрхийн тухай тунхаглалд хөгжил гэдэг нь нийт иргэд, хувь хүмүүсийн идэвхтэй, чөлөөт оролцоонд тулгуурлан гарч буй үр ашгийг шударгаар хуваарилах, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын цогц үйл явц мөн хэмээн тодорхойлсон байдаг. Мөн Венийн тунхаглал болон үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжих эрхийн

⁴ “НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200 А/XXI/ тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон”

үзэл санаа илүү тодорхой тусгагдсан бөгөөд хөгжлийн төвд хүнийг тавьж, хүн эрх, эрх чөлөөг бүрэн эдлэх нөхцөл үндэс болохыг онцолдог гэж тэмдэглэсэн байна. Ялангуяа хөгжлийн боломж бүрдээгүй эсвэл эрхээ эдэлж чадахгүй байгаа хүмүүсийн асуудал өнөөгийн хөгжлийн түвшинд зөвтгөх аргагүй зүйл гэж үздэг бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдсэн, ял эдэлж буй хоригдолд ч хамаарах асуудал юм.

Аливаа засаглал нь цөөнх бус нийтийн төлөө, тэр дундаа эмзэг бүлэг, амьдрал доройтсон хүмүүс, үндэсний цөөнх зэрэг эрсдэлтэй бүлгийн төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой. Тиймээс хүний эрхийг хуульчилж хамгаалах, хүний эрх, эрх чөлөө, нэр төрд халдах аливаа үйлдлээс хамгаалах нь төрийн гол үүрэг бөгөөд улс орнууд үүнийг хүлээн зөвшөөрсөн байна. “Энэ үүргийн хэрэгжилт нь олон улсын харилцааны чухал үзүүлэлт болжээ. Хөгжих эрхийн үзэл санаа нь зөвхөн өнөө үе төдийгүй хойч үеийнхэн ч эрхээ эдлэх, хөгжих бололцоотой байх ёстой гэж үздэг. 1992 оны Иогийн тунхаглалын гуравдугаар зарчимд Хөгжих эрх нь хойч үеийн хөгжлийн болон байгаль орчны хэрэгцээг харилцан тэнцвэртэйгээр хангах замаар хэрэгжих ёстой гэж заасан нь хүний эрх, хөгжил хоёр харилцан бие биеэ нөхцөлдүүлдэгийг илэрхийлнэ”. (ХЭҮК, Хүний эрхэд суурилсан хандлага. Гарын авлага. , 2016, хууд. 83)

“Эмэгтэй хоригдол, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хүлээсэн эмэгтэйчүүдтэй харьцах стандартыг заасан дүрмийн⁵ 5-р зүйлд Эмэгтэй хоригдлын байрыг эрүүл ахуйн тусгай хэрэгцээнд нийцүүлэн тохижуулж, шаардлагатай эд зүйлээр хангах, хүүхдэд хувийн хэрэглээний цэвэр усаар тогтмол хангах, сарын тэмдэг ирсэн үед ариун цэврийн хэрэглэлээр үнэ төлбөргүй хангах талаар тусгасан байна. Мөн Хүүхдийн эрхийн конвенцод нэгдэн орсон улс орнууд Хүүхдийг баривчлах, цагдан хорих, хорих нь хамгийн сүүлийн арга хэмжээ байх бөгөөд богино хугацаанд хэрэгжинэ гэж заасан ба хүүхдийг нийгэмд эргэн нэгтгэхийг дэмжих заалтууд орсон байна.

“НҮБ-ын Насанд хүрээгүй хүний хэрэг хянан шийдвэрлэх наад захын жишиг дүрмийн 24.1, 26.1-д эрх чөлөө хязгаарлагдсан хүүхдийг сургах, нийгэмшүүлэх, боловсрол болон мэргэжлийн чадвар эзэмшүүлэх зэрэг үйл ажиллагааг дэмжих талаар заасан. Мөн насанд хүрээгүй хүний гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх НҮБ-ын удирдамж нь хүүхэд, өсвөр үеийг нийгэмшүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээг багтаадаг.

⁵ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2010 оны A/RES/65/229 дугаартай тогтоолоор батлагдсан.

Хоригдлын эрхийг хангах, нийгэмшүүлэх үйлчилгээг хүргэхийн тулд ял эдлэх хоригдлын дотор хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн эргэлтгүй, амьжиргааны түвшин доогуур, ахмад настай, эмэгтэй, хүүхэд зэрэг зорилтод бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг тогтвортой хүргэх, зах зээлийн эрэлтэд нийцсэн боловсрол, мэргэжил олгох, гэр бүлийн гишүүдтэй холбоо тогтоох, суллагдсаны дараа хөдөлмөрийн зах зээлд зуучлах зэрэг олон үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай”. (НҮБ, 2023)

Олон улсын түвшинд хоригдлыг нийгэмшүүлэх ажил хүний эрхийг эрхэмлэн хөгжих хандлагатай болж, ядуурлыг бууруулахад чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээний хэрэгцээг хүлээн зөвшөөрч байна. Хүний эрх, хөгжлийг идэвхтэй оролцоотой хослуулах нь илүү үр дүнтэй байдаг. 1997 онд НҮБ-ын Шинэчлэлтийн хөтөлбөрт хүний эрхийн үзэл баримтлалыг бүх байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхийг уриалсан бөгөөд үүний үр дүнд олон байгууллага хамтран “Нийтлэг ойлголцлын мэдэгдэл” боловсруулсан. Энэ нь хүний эрхийн хэм хэмжээ, стандарт, зарчмыг хөгжлийн бүх үйл явцад нэвтрүүлэхэд чиглэсэн ойлголт юм.

Олон улсын хорих байгууллагуудын холбооны бага хуралдаанууд дээр “Энгийн амьдралын тухай бодох” (XV бага хурал) болон “Хоригдлыг нийгэмшүүлэх орилгыг нь өөрчлөх” (2014 оны 16 дугаар бага хурал) сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. (From incarceration to Reintegration: Change with a Purpose, 2024)

Олон улсын нийгмийн ажлын хүрээнд хорих ял эдэлж буй хоригдол, суллагдсан хүнд хууль эрх зүйн тусламж, хоол унд, хувцас, орон байрны дэмжлэг, сэтгэл зүйн зөвлөгөө, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэх нь чухал. Судлаачид, эрдэмтэд сүүлийн үед анхаарлыг нь татсан асуудал нь хоригдлыг хөлсгүй ажиллуулах буюу орчин үеийн боолчлол, хүний наймаанд өртөх эрсдэл бөгөөд үүнд бэлгийн дарамт, хууран мэхлэлт, дарамт шахалт, гэмт бүлэгт элсүүлэх зэрэг сөрөг үзэгдлүүд багтдаг. Иймээс хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг олон улсын түвшинд хөгжүүлэх шаардлага улам нэмэгдэж байна.

“Эмэгтэй хоригдлыг нийгэмшүүлэх, эмэгтэй гэмт хэрэгтэнд ял оногдуулах асуудлыг Бангокийн дүрэмд⁶ тусгайлан заасан бөгөөд хорих

⁶ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2010 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 65/229 тоот тогтоолоор батлагдсан.

ангийн удирдлага, нийгмийн халамжийн байгууллага, орон нутгийн болон төрийн бус байгууллагууд хамтран эмэгтэй хоригдлыг суллагдахын өмнө болон дараа нийгэмд эргэн нэгтгэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг онцолжээ.

Олон улсын нийгмийн ажлын үндсэн байгууллагууд болох НҮБ, UNICEF, Хүүхдийг ивээх сан, Эмнести интернэшнл, Улаан загалмай, Энх тайвны нийгэмлэг, Хүний эрхийн байгууллага, Нийгмийн ажлын сургууль, Нийгмийн ажлын олон улсын холбоо зэрэг байгууллагууд нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжиж, хоригдол, суллагдсан хүн, хүний наймааны хохирогчид сэтгэл зүйн болон эрүүл мэндийн тусламж үзүүлж, нийгэмшүүлэхэд чиглэсэн үе шаттай ажлыг зохион байгуулж байна”. (Хандмаа & Мөнхбат, 2016, хуудсд. 185-186)

“Дэлхийн ихэнх улсын хорих байгууллагад хүний эрхэд суурилсан нийгмийн ажил хөгжиж, олон улсын хэм хэмжээний баримт бичгийг удирдамж болгон шинэ ирсэн хүний нөхцөл байдлыг үнэлж, нийгэмшүүлэх үйлчилгээ, ганцаарчилсан болон бүлгийн дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн тусламжид шилжүүлэх, нийгэмшүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үүрэг гүйцэтгэдэг”. (Тимофеева, 2018)

Хорих байгууллагын нийгмийн ажилтан хоригдлын нийгэмшилд гарч буй ахицын талаарх мэдээллийг дэвтэрт тэмдэглэж, тайлан гарган хяналтын байгууллага, шүүхэд танилцуулдаг нь нийтлэг жишиг болжээ. Олон улсын хорих системд хоригдлын анхны үнэлгээ нь сэтгэл зүйн эрсдэлтэй, түгшүүртэй, сэтгэлийн хямралтай эсэхийг тодорхойлох, өвчний түүх, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг талаар хамтарсан дүгнэлт гаргах зэрэг явцад нийгмийн ажилтан оролцдог. Үнэлгээний үе шатанд хоригдлын өвөрмөц хэрэгцээг тодорхойлж, бусад байгууллага, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор нийгэмшүүлэх төлөвлөгөөг боловсруулж, суллагдах үйл явцад бэлтгэдэг. Энэхүү төлөвлөгөөнд ганцаарчилсан зөвлөгөө, мэргэшсэн үйлчилгээний бүлэг, тохиолдлын менежмент зэрэг багтдаг. Давуу тал дээр суурилсан нийгэмшүүлэх үйлчилгээ нь хөдөлмөрт хуваарилах, мансууруулах бодисын донтолттой тэмцэх, эрүүл мэндийн ноцтой асуудалтай хоригдолд үр дүнтэй байдаг. (холбоо, 2024)

“Монгол Улсад олон улсын бодлого, эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага бий. Учир нь энэ ажил нь хорих ангийн өвөрмөц орчинд,

эрүүгийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйгээр дамжин хэрэгжиж буй шинжлэх ухаанд суурилсан нийгмийн ажил юм”. (Баярбаатар, 2024, хууд. 87)

ДҮГНЭЛТ

Дэлхийн II дугаар дайнаас хойш хорих ялын тоо эрс нэмэгдэж, олон улсын байгууллагууд үүнийг бууруулах шаардлагатай гэж уриалж буй ч зарим бүс нутагт хорих ял оногдуулалт илүү хурдтай өссөн нь хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгцээг бий болгож байна. Хоригдлын онцлогийг харгалзан, үе шаттай, зохион байгуулалттай нийгэмшүүлэх үйл ажиллагаа явуулах нь тэднийг нийгмийн идэвхтэй, ашигтай харилцаанд оруулж, ёс зүй, эрх зүй, гоо зүй зэрэг үнэт зүйлтэй, сэтгэл зүйн хувьд эерэг хүн болгон төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой. Гэвч хорих ял нь их хэмжээний зардал, суллагдсан хүнд дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл өндөртэй байгаагаас, олон улсад аль болох хорих ялнаас өөр, "альтернатив ял"-ыг хэрэглэхийг дэмжиж байна. Энэ нь хоригдлыг нийгмээс тусгаарлахгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоон, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэлбэр юм.

НҮБ болон бусад олон улсын эрх зүйн баримт бичгүүд нь хүний эрхийг дээдэлсэн хандлагыг зөвшөөрч, хорих ял эдэлж буй хүнд хүний нэр төр, үнэ цэнийг хүндэтгэх, хэрцгий харьцааг хориглохыг онцолдог. Түүнчлэн хоригдлыг зөвхөн яллагдагч бус, ирээдүйд нийгэмд эргэн нэгтгэх, засаж залруулах ёстой хүн гэж үзэн, нийгэмшүүлэх, боловсрол олгох, хүмүүжлийн нөлөө үзүүлэх, хөдөлмөрийн чадвар эзэмшүүлэх замаар гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэх үүрэг хүлээлгэдэг.

Монгол Улсын хувьд олон улсын энэхүү эрх зүйн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хүний эрх, шударга ёс, боловсрол, нийгэмшүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах шаардлага тулгарч байна. Боловсрол нь зөвхөн мэдлэг олгох биш, хувь хүнийг нийгэмд дасан зохицох чадвартай, хүний эрхийг хүндэтгэдэг иргэн болгон төлөвшүүлэх чухал хүчин зүйл гэдгийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөн. Иймд хорих ялыг үр дүнтэй, хүнлэг, хүний эрхэнд суурилсан байдлаар хэрэгжүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах, хоригдлыг нийгэмд эргэн нэгтгэх гол зам юм. Энэ үйл явцад төрийн эрүүгийн бодлого, хууль тогтоомж, хорих байгууллагын үйл ажиллагаа, хүний эрхийн хэм хэмжээ

зэрэг олон хүчин зүйлсийг зохицуулан хамтад нь хэрэгжүүлэх нь чухал байна.

Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагаа нь хүний эрхийг хүндэтгэх, хувь хүний хөгжлийг дэмжих, давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх олон талт, цогц бодлого, хөтөлбөр хэрэгжих шаардлагатай чухал үйл явц юм. Олон улсын эрх зүйн баримт бичгүүд болон практик туршлага нь хоригдолд чиглэсэн хүмүүнлэг, хөгжилд суурилсан хандлагыг баримтлах ёстойг илтгэж байна. Монгол Улс ч мөн адил энэхүү чиг хандлагыг дотоод хууль тогтоомж, бодлогын баримт бичигтээ тусган, хэрэгжилтийг нь сайжруулах шаардлагатай байна. Хоригдлыг нийгэмшүүлэх ажил нь зөвхөн хорих байгууллагын үүрэг биш бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн хамтын ажиллагаа, оролцоонд суурилсан байх ёстой.

САНАЛ

Нийгэмшүүлэх үйл ажиллагаанд чиглэсэн тусгай хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Хоригдлын боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгай хөтөлбөрүүдийг хуулиар баталгаажуулж, хэрэгжилтийг хянан шалгах тогтолцоог бүрдүүлэх.

Хорих байгууллагын боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх. Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хуульч, боловсролын мэргэжилтнүүдийг нэмэгдүүлж, тогтмол сургалтаар хангах.

Хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх, сургалтад хамруулах бүтцийг сайжруулах. Ажил олгогч байгууллагуудтай хамтран сургалт, үйлдвэрлэл хослуулсан загваруудыг нэвтрүүлэх; гар урлал, мэдээллийн технологи, жижиг үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжил олгох.

Гэр бүл, нийгмийн холбоог дэмжих хөтөлбөрүүд хэрэгжүүлэх. Хоригдлын хүүхэд, гэр бүлийнхэнтэй холбоотой харилцааг сэргээх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох.

Хоригдлын нөхцөл байдалд хяналт тавих хараат бус тогтолцоог төлөвшүүлэх. Иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийн байгууллагын оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах.

Олон улсын туршлагыг судалж, нутагшуулах. Ял эдэлж буй хүнийг нийгэмд дахин нэгтгэх чиглэлээр амжилттай хэрэгжүүлж буй орнуудын загвар, арга барилыг судлан нутагшуулах.

Эх сурвалж

Retrieved from www.icpa.ca/news-icpa. (2024).

Батжав, Л. (2003). Криминологийн зарим асуудал. Улаанбаатар.

Батжав, Л. К. (2003). Батжав, Л. Криминологийн зарим асуудал. Retrieved from Батжав, Л. Криминологийн зарим асуудал. .

Баярбаатар, П. (2024). Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт. Улаанбаатар.

ДХБХ. (2023). Дэлхийн Хорих байгууллагын холбоо. Retrieved from (WPB) сайт. <https://www.prisonstudies.org/>.

Дэлхийн Хорих байгууллагын холбоо (WPB) сайт. <https://www.prisonstudies.org/>. (2025). Retrieved from Дэлхийн Хорих байгууллагын холбоо (WPB) сайт. <https://www.prisonstudies.org/>.

зүйл, М. У. (2017). Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйл.

Монгол Улсын ХЭҮК. Хүний эрхийн баримт бичиг, з. т. (2014). Монгол Улсын ХЭҮК. Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. . In з. т. Монгол Улсын ХЭҮК. Хүний эрхийн баримт бичиг.

НҮБ, 10 (Өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх тухай НҮБ-ын удирдамж (Резадхын удирдамж) 10 дугаар зүйл. (2023).

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, т. б. (1984). НҮБ-ын Ерөнхий ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан. In т. б. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж.

Очгэрэл, Ц. “. (2017). Очгэрэл, Ц. “Хорих байгууллагын аюулгүй байдал”.

Тимофеева, Е. (2018). Хоригдлыг нийгэмшүүлэх гадаад орны туршлага. Москва.

Хандмаа, С., & Мөнхбат , О. (2016). Нийгмийн ажлын 101 карьер. Улаанбаатар.

холбоо, О. У. (2024). Retrieved from icpa.org/news.html.

ХЭҮК. (2016). Хүний эрхэд суурилсан хандлага. Гарын авлага. . Улаанбаатар.

ХЭҮК. (2016). Хүний эрхэд суурилсан хандлага. Гарын авлага. . Улаанбаатар.

ХЯЭА, 266.1.5 (Төрийн эмхэтгэл мэдээллийн систем 2025).